

## "Оргил хүнс"-ийнхэн "Гоё" таргаа хятад таргаар савладаг

2013 оны 6 сарын 18



Өчигдөрхөн л "Home Plaza" сүлжээ дэлгүүр хятад хүнсний бүтээгдэхүүн оруулж ирдэгээ улайм цайм мэдээллийн сайтуудаар "мэдэгдсэн" бол өмнө нь яригддаг байсан, одоо ч яригдаад байгаа хятад үнэ хямд чанар муутай хүнсний бүтээгдэхүүнээр тэр тусмаа Витафит ХХК-ийн салбар "Оргил хүнс"-ийн Гоё тарга бидний ходоод гэдсийг хордуулж байгаа талаар "Нийгмийн толь" сонинд ийхүү бичжээ

Нүүдэлчин Монгол түмний эртнээс уламжлагдаж ирсэн хуруу дарам цөөн хоолны нэг нь тараг. Тараг амьд хоол. Махгүй болсон тохиолдолд тарагаар өл залгаад хэдэн сар ч байж чаддаг нь монголчууд. Тиймээс л энэ төрлийн идээг өнөөдрийг хүртэл боловсруулан

хэрэглээнээс халаагүй. Манай улсын нөөцийн найман нэрийн бараанд багтдаг амин дэмээр баялаг энэ хүнсийг өдгөө харийн технологиор хийж байна гэх шүүмжлэл энэ асуудлыг хөндөхөд хүргэв. Өргөн хэрэглээний бараа материалын 80 гаруй хувийг урд хөршөөс авдаг манай улс өдгөө үндэснийхээ цагаан идээг ч өөрсдийн гараар хийж чадахаа байжээ. Үүний жишээ нь Хятадаас орж ирж буй үй түмэн чанаргүй хүнсний бүтээгдэхүүний нэг нь цагаан дээр хараар "Монгол" гэж бичсэн урд хөршийн тараг. Бидний бяцхан үрсээр сурталчилгаа хийж, "гого" гэж дуулан олноо танигдсан, гаднаа гяланцаг дотроо паланцаг "Оргил хүнс" компанийн "Гоё" тарагийг дагасан асуудал анхаарал татаад болдоггүй. Учир нь энэ компани жишээ, жишээний дээд болж, зөрчилтэй компаниудын тэргүүн эгнээнд жагсаад байгааг учир мэдэх нэгэн хэлж буй. Тус компани Монгол түмний уламжлалт идээ болох тарагийг хоол амталж байгаа юм шиг амтлаад хадгалалтын хугацааг зориуд өөрчилж худалдаж байна гэв. Энэ мэдээлэлтэй зэрэгцэн нэгэн асуултыг уншигч авхай таниас асууя. Би хөдөө төрж эмээгийнхээ бүрсэн тарагийг идэж өссөн тийм л нэгэн жирийн иргэн. Тэгвэл монгол амтыг санаж буй танд сануулахад, жинхэнэ ориг монгол тарагийг даруй идэхгүй бол нэг хоногийн дотор исэж гашуурдаг даа. Гэтэл "Гоё" гэх энэ тараг ид шидтэй гэмээр гурван сар хадгалах хугацаатай байх юм. Энэ нь 90 хоног хадгалаад ч гашуурч, исэхгүй гэсэн үг. Гэтэл Монгол үнээний тараг хэдхэн цагт л исч сагадаг байтал, "Гоё" тараг ийнхүү нэг л амтаараа гурван сар болно гээд байгаагийн учрыг лавламаар байна.










Энэ юу гэсэн үг вэ, хоол хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хянаж байдаг салбарын байцаагчид аа. Хаана байна вэ, хүнсний аюулгүй байдал хэмээн ярьж хааяахан зурагтаар шоуддаг хэсэг нөхөд өө. Одоо л та нөхдийн хяналт, шалгалт хэрэгтэй байна. Учир нь барбарис чихэрнээс жоом, компотноос өт, талхнаас лент, "Гоё" жүүснээс хөгц гээд л юу, юу гэнэ вэ шинэ өглөө бүр шинэхэн аюул сонсогдох нь хэвшил болж, энэхүү сэтгэл сэрхийлгэм мэдээнд бид дасах шинжтэй. Ёстой л өнөөх тэнэгийн дотор уужуу гэгчээр Монголчууд бид "Гоё" хэмээх энэхүү тарагийг олон хууль зөрчсөн, шаардлага хангаагүй, Хятадад үйлдвэрлэдэг гэдгийг мэдсэн хэрнээ л "Тийм гэнэ лээ" гээд л уусаар байна. Андуураагүй бол Эрүүнд яг ийм амттай тараг идсэнээ тухайн үед гайхширч байснаа дурдъя. Арай манайх урдаас "Гоё"-ийг оруулж ирдэг юм биш биз гэх хар төрөөд болдоггүй ээ. Хэнбугай ч хэлнэ дээ, Эрээний захын дэлгүүрийн лангуун дээр эрийтэл нь өрчихсөн байдгийг. Үүнийг шалгамаар байна. Хяналтгүй урд хөршөөс угшилтай тараг манай хүнсний зах зээлд хэдийнэ ганхашгүй байр эзэлж өөрийн гэсэн худалдан авагчтай болсон нь сэтгэл эвгүйцүүлнэ. "Гоё"-ийн хэрэглэгчдийн ихэнх хувийг хүүхэд, багачууд эзэлж байгаа нь санаа зовоож буй шалтгаан энэ юм. Монгол Улсын "Эсэж цагаан идээ, техникийн шаардлага" MNS 4229:2011 стандартыг 2011 оны арванхоёрдугаар сарын 16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Гэтэл "Гоё" тараг нь 2009 оноос хойш стандарт зөрчсөн, одоо ч зөрчиж буй гол бүтээгдэхүүн аж. Үүнийг мэргэжлийн хяналтынхан дутуу хянаж, худалдан борлуулах дүгнэлт удаа дараа үйлдсэн байх юм.

Өөрөөр хэлбэл, "Оргил хүнс" компани хууль бус дүгнэлтээр үйл ажилгаагаа явуулсаар өдийг хүрчээ. МХЕГ-ын байцаагчийн дүгнэлт үнэн эсэх нь эргэлзээтэй. Учир нь 2012 оны нэгдүгээр сарын 16, дөрөвдүгээр сарын 19, долдугаар сарын 25-ны өдрийн байцаагчийн дүгнэлтээр шинжилгээ хийгдээгүй байдаг. Харин 2012 оны аравдугаар сарын 9-ний өдөр Нян судлалын лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тараганд байх "Ашигтай бичил биетийн тоо" байх ёстой хэмжээнээс 50 дахин бага гарч, стандартын шаардлага огт хангаагүй гэсэн хариу гарсан байгаа юм. Уг нь стандартын тараганд 1x10-ын долоон зэрэгт байх ёстой аж. Тэгтэл "Гоё" тарганд асуудал гарч өнөөх хэмжээ 2x10 таван зэрэгт гарчээ. Үүгээр ч дуусаагүй. Уг дүнг дахин баталгаажуулахаар "Хэрэглэгчийн эрх, боловсролын холбоо" дахин өнгөрсөн тавдугаар сарын 23-нд "Оргил хүнс" компанийн үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэдэг 1.5, 1л, 450 гр, 125 граммын бүтээгдэхүүнээс дээж авч МХЕГ-ын нэгдсэн төв лабораторид шинжлүүлэхэд ашигтай бичил биетийн тоо 100 дахин бага гарчээ. Энэ олон дүгнэлтийг харахад энэ чинь одоо тараг мөн үү хэмээн асуумаар. "Ориг" тараг исэхгүй, гашуурахгүй байж болдог юм уу. Химийн бодисгүй монгол тарагийг 90 хоног хадгалж үнэхээр болдог эсэхийг "Гоё"-ийн үйлдвэрлэгчдээс асуумаар байна.

Их уншсан

Шинэ мэдээ

Их сэтгэгдэлтэй

-  **Түргэн секс хийхэд тохиромжтой 8...**  
2014 оны 3 сарын 21
-  **Топ модель Д.Пүрэвсүрэнгийн нууц ...**  
2014 оны 3 сарын 19
-  **Найз бүсгүйгээ нүд хальграм...**  
2014 оны 3 сарын 22
-  **Шөнийн клубт загас наадуулж байгаада...**  
Өчигдөр 11 цаг 0 минут
-  **Оросын шөнийн клуб дахь нүцгэн шоу +18**  
2014 оны 3 сарын 21
-  **Эр хүний нэрийг гутаасан хүү**  
2014 оны 3 сарын 19
-  **Какуюроу М.Ананд түрүүлж аваргын...**  
Өчигдөр 8 цаг 18 минут
-  **Б.Наранхүү төрийн ажил хийгээд байна...**  
Өчигдөр 8 цаг 57 минут
-  **Аймшигт авто ослууд (насанд хүрэгчдэд)**  
2014 оны 3 сарын 1

Сэтгэгдэл бичих:

UNEN.mn  
ХҮН БҮР ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХТЭЙ

Манай сайт танд таалагдаж байвал LIKE хийгээрэй. Танд баярлалаа.


Follow @unen\_mn1 3,191 followers

Сэтгэгдэл Илгээх Хэвлэх

Like 11

Tweet 4

Санал болгох



Хүн сармагчингаас үүссэн гэдэг нь үнэн л...



Шөнийн клубт загас наадуулж байгаад...



6 давхраас бяцхан охин унав



Эрүүл зөв турaxын тулд хэрхэн хооллох вэ?



Залуустаа хандаж илгээх миний захидал



Найз бүсгүйгээ нүд хальтрам аймшигтай зоджээ



Нүдэндээ итгэмээгүй юм аа



Хөгжилтэй бүжиг

Сонин хачин

Follow @mglnews



Загвар өмсөгч, дуучин Lana Del Rey ба түүний



МН370 нислэгтэй хамт алга болсон мөрөөдлүүд



Шүүмжлэлд яаж хандах вэ?



Эдийн засагт хэргцээгүй импорт хумигдсан



Хүнсээр бүтээсэн дэлхий газрын зургууд



Махны үнэд "дарлуулсан" мал аж ахуйн орон...



Барилгын зөвшөөрөлтэй эсэхийг гар утаснаасаа




Оффисийн хөгжилтэй зургууд

Холбоотой мэдээ »

Өмнөх мэдээ »

Дараах мэдээ »



- Майк Тайсон: Би хэтэрхий...
- Сонгуулийн өмнө уул...
- Р.Гончигдорж нарын...
- "Ромео Жульетта" мюзиклд...
- Шашны байгууллагын үйл...



- Эгэл хийгээд энгүй таныг...
- "Бэр гуйх ёслол"-ыг англи...
- Ослоор амиа алдсан иргэн...
- Дэлхийн хамгийн их...
- АНУ Оросын тэргүүнүүдийг ...

Нэр:

Сэтгэгдэл: (31)

Сэтгэгдэл:

Илгээх

**АНХААРУУЛГА:** Уншигчдын бичсэн сэтгэгдэлд [ipen.mn](#) хариуцлага хүлээхгүй болно. ХХЗХ-ны журмын дагуу зүй зохисгүй зарим үг, хэллэгийг хязгаарласан тул ТА сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээг зөрчсөн сэтгэгдлийг админ устгах эрхтэй. Сэтгэгдэлтэй холбоотой санал гомдлыг **11321287** утсаар хүлээн авна.

**гоё шдээ(103.26.194.158)**

2014 оны 2 сарын 14 \ Яагаад зөвхөн гоё-г бичээд бна? Хэдэн бор юм авциймуу. Шалгаад өгдөг газар байдгийшд.

0 0



**Батука(103.10.22.142)**

2014 оны 1 сарын 29 \ Энэ Цэрэн гээд \*\*\*\*\* үндэслэлгүй мэдээлэл цацсан гээд шүүхдүүлж Тэрэндээ Оргил хүнс ялчихсан шдээ. Ингэж \*\*\*\*\* тараг гэж хуцаж байхаар үйлдвэр дээр нь очоод үзчихээч малнууд минь юу юугаа ч мэдкү чацганууд байж

0 0



**Зочин(122.201.28.4)**

2014 оны 1 сарын 6 \ хахаха

0 0



**Зочин(124.158.73.3)**

2013 оны 6 сарын 24 \ ugasa l huja tarag shd medehgvi hen bsiin hugiin yumnuud saw baglagiin l soliod boloo

0 0



**anji(202.126.91.74)**

2013 оны 6 сарын 20 \ ene odoo yu we. har pi r yawuulga ch geh shig. uuruu hujaagaas oruulj irdeg nuhur n yum bn l daa. goe tarag ugaasaa l hujaaa sh dee. ene targiig dandaa joohon huuhduud uuj bga. mungunii tuluu negniigee horlohoos ch butsaogui shunaliin tulamnuud. mergejliin hyanaltiinhan gej bas mungu urdaas n chuluudchihaar amaa bariulchihdag shunалууд bhiin. eeh medehgui medehgui.

1 0



**unshigch(122.201.18.8)**

2013 оны 6 сарын 20 \ arai denduu ymaa baliar ymnuud mungunii tuluu yu ch hiihees butskuu ymaa Etseg ehchuud n mongol tarag gj bodood l ur huuhduuddee awch ogch bgaashd

0 0



**husel(124.158.74.2)**

2013 оны 6 сарын 19 \ Ugaasaa ene huns bugd HULHI !!! Narantuul deer baigaa chiher busad zuiliin konteinert zarj baigaa yum bugd HUUJAA ene Mergejliin hynaltiinhan er yu hiigeed байна!!!Tuuniig shalgaach!!!Oros geed l dandaa huuramch chiher \*\*\*\*\*...Arai chdee Bat-Uul dargaa

0 0



**Зочин(202.126.89.192)**

2013 оны 6 сарын 19 \ goyo ch eseh n esdeg yum bilee bid chadaogui bish shingen suu аваад l taragaa bured uuchhaya lda tegvel boloo er n bodniig ooriigoo huurch huuramch ideh yum oruulj irehee bolimoor yum shuugdej uilee edlehee meddeggui bol medej av

0 0



**Зочин(202.131.234.50)**

2013 оны 6 сарын 19 \ Худлаа мэдээлэл байна. Манайх лав хүүхдүүддээ 1 настайгаас нь хойш 2 жил өгч байна. Яг монгол улсдаа цэвэр үнээний сүүгээр үйлдвэрлэж байгаа таргийг яаж хятад тараг гэж хэлж байна. Энэ бичээд үзээд байгаа хүн зөвхөн Гоё таргийг л яриад байх юм. Яагаад бусдыг нь яридаггүй юм. Бусад таргууд ч гэсэн Гоё тарагтай адил исэхээ болиод удаж байна ш дээ. Тэгэж савласан бүх таргууд л адилхан исдэггүй. Аягүй бол яг үнэндээ бусад нь Гоё-с муу байгаа даа.

0 0



**Mongol(83.233.163.2)**

2013 оны 6 сарын 19 \ En har piar iig hiigeed bg nohor goe targnii uildverees mong neheed bolohgui bolhoor n engej bg gej sonsson yum bn uildver n 3 r stahilgaan s tanstiiin hajuud baidag yum manaihaan ochood l uzchih oor asuudal alгаа enend negniigee yum hiiheer engedgee bolimoor yum aa en mongo nehseu nohor bolimoor yum

1 0



**aisdja(202.126.91.159)**

2013 оны 6 сарын 18 \ oischakjdhlidjf

0 1



**Зочин(112.72.12.24)**

2013 оны 6 сарын 18 \ Goe tarag no toi

1 1



**Гоё тарагтай өшөөтэй хүн юуму хаашайн(182.160.14.20)**

2013 оны 6 сарын 18 \ Байнагал гоё тарагны талаар бичихын. Өөр бичих юм байдаггүй юмуу. Энэ Гоё тарагийг үйлдвэрлэж байгаа Компани нь яаж хийж байгаагаа болвол бодтойгоор харуулсан ТВ нэвтрүүлэг нтр хийж цацаж нэрээ цэвэрлэж авмаар юмаа. Уг нь манайх их авдаг байсан сүүлдээ айдаг болжино шүү

0 0



**Nergui(27.123.214.2)**

2013 оны 6 сарын 18 \ Naadah chin ugasa hujaa tarag shde, tgd ch manai ger bulinhen heregledeggui,,, Bitgii heregleerei manaihaan, sonschood martad heregled toohgui yvad bdg shu!!!!

1 0



**Зочин(124.158.94.35)**

2013 оны 6 сарын 18 \ archaagui malnuud gej bidniig l helne. hamgiin orig huns hereglej suuh bolomjtoi murtluusuu unjaad bhaar unaad ireesei geed l hevtej baidag teneg ulsuud

0 0



**Зочин(124.158.94.35)**

2013 оны 6 сарын 18 \ ugaasaa busad uildveriin tarag ch isehee baichihsan shuu dee :(

1 0



**Зочин(182.160.23.7)**

2013 оны 6 сарын 18 \ setgegdal orohgui bn

0 0



**uugi(182.160.23.7)**

2013 оны 6 сарын 18 \ ene ch unen bhaa lav l eruul huns bish reklamdaad bhaar ni 1-g avch uuj uzsen neg sonin haimar unerteed amtagdaad bna lee

1 0



**Зочин(103.9.89.202)**

2013 оны 6 сарын 18 \ bugdeereel avhaach uuhaach bolichiildoo

0 0



**Зочин(27.123.214.110)**

2013 оны 6 сарын 18 \ humuus zugeer l uildver deer ni ochood uzeesei. 3-r stanciin zuun tald bgaa. tarag hyatadaas oruulaad bna gj bhgui shuu dee. hen negnii doosh ni hiih gesen yavuulga l bna.

0 0



**Зочин(27.123.214.110)**

2013 оны 6 сарын 18 \ humuus zugeer l uildver deer ni ochood uzeesei. 3-r stanciin zuun tald bgaa. tarag hyatadaas oruulaad bna gj bhgui shuu dee. hen negnii doosh ni hiih gesen yavuulga l bna.

0 0

**zol(180.235.177.40)**

2013 оны 6 сарын 18 \ manaihan bugdeerei l awahaa bolichwol zarahaa bolinio bizde ugssaa ene tarag unen aimar 2 nastai duude uulgaad bsan chini \*\*\*\*\* tulegdeed yum gartsan joochon huuhtiin \*\*\*\*\* chini ugas aimar emzег bhor gdes hodoodond ni yaj nuluuluj bga ni oilgomjtoi bga bizde tged neeh aimar saw ulaigad tsagaan idee hiisen saw chini tsagaan boldog bizde getel ene taragni saw ulaadag unen aimaar

0 0

**Zochin(182.160.5.153)**

2013 оны 6 сарын 18 \ Дотоодын үйлдвэрлэгчдийг ингэж гүтгэн доромжилохоо одоо зогсоох цаг болсон юм бишүү. Үйлдвэрийг нь, таргаа ямар түүхий эдээр хийдэг, ариун цэврийн ямар нөхцөлд үйлдвэрлэж байгааг нь очиж үзчихээд дараа нь бичих юмаа бичих хэрэгтэй. Энэ бол арай хэрээс хэтэрч байна. Ганц хүн бодит байдлыг гуйвуулж олон удаа бичээд байхаар нийгэмд буруу ойлголтыг газар авахуулж байгаад харамсаж байна. Сүүгээ авч байгаа фермийг нь ч гэсэн очиж үзэх хэрэгтэй. /Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт баг "Атарчандгана сүү" компанийн фермээс сүүгээ авч байгаа/

1 1

**Зочин(182.160.16.51)**

2013 оны 6 сарын 18 \ hujaa ezente shu de zondool bulhai luivar bga goe tarag ni savin udaan bailgad uzeree dotron ulaigad aimar ym boldog huni hodod timel bolj bga da ter goe targanas bugd tatgalzay humuus ajilaa hiigechee hahul avch bhar

0 0

**udw\*\*\*\*(203.169.50.54)**

2013 оны 6 сарын 18 \ eroosoo buh humuusee awaxaa l bolichih eo do

0 0

**San\*\*\*\*(203.169.49.7)**

2013 оны 6 сарын 18 \ borluulalt hiih geed irehed n Hvnnsii delgvrvvd Awahaa bolij vzwel yaaasii

0 0

**Зочин(122.201.18.191)**

2013 оны 6 сарын 18 \ EOOO YASAN BALIAAR HAR NOVSHNUUD VE. ENE TARGIIG CHIN CHUHAM L GOE SAIN GEED HUUHUUUDDEE AVCH OGCH UULGADAG BSAN SHDEE. TIMCHUUUD BID NAR OORSDOO CH UUI CHADAHGUI HUUHUUUDDEE UULGAJ BSAN MAANI TEGEED ODOO ENE UU. NEG MUU HUJAAAGIIN HOROOR HUUHUUUDEE HORDUULCHIIHAAD OORSDOO HUUHUUUDEE BODOJ BGAA NEREER HOR IDEHGUI ULDEJ BSAN BNA SHDEE. JIREMSEN HUUHNUUD CH GESEN ZONDOO L AVCH BGAA HARAGDDAG BSAN. ARAI DENDEJ BGAA UM BISH UU. ZAVAAAN HAR SHUNALTAI NOVSHNUUDAA. TA NARIIN HALTAR TOGROG HICHNEEN AILIIN HUUHUUUDEED HOR HONOO L BOLJ BGAAG MEDEJ L BGAA BMAAR UM.

0 0

**зочин(202.179.11.58)**

2013 оны 6 сарын 18 \ манай улс хил гаалиар орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг нарийн шалгах цаг болсон ганц тараг ч биш ,ялангуяа жимс нарийн ногоо,ядахдаа стандартад заагдсан хэлбэр дүрстэй алим байх ёстой биздээ , нөгөө хянаад шалгадаг мэргэжлийн хүмүүс нь яагаад дугарахгүй байгаа юм ,эсвэл мэдлэг муутай хуурамч дипломтонгууд,эсвэл авилгачид л байх .мэддэг зарим нь солонгосоос хүнсээ цуглуулдаг гэсэн ,эцэст нь хөөрхий ард түмэн хохирч байгаа шүү . СҮҮЛИЙН үед яагаад хавдрын өвчлөл ихсээд байна ,хавдар судлал дээр баяр наадам болж байгаа мэт л хүн цугларч байна энэ чинь хүнсний аюулгүй байдал алдагдсаны шинж ,үүнийг одоо таслан зогсоох хэрэгтэй.Америк,Япон ялгаагүй л Хятадаас импортлодог гагцхүү яг стандарт,лабораторийн шинжилгээг хатуу барьдаг бид яагаад хэрэгжүүлж чаддаггүй юм.

0 0

**Зочин(114.32.141.128)**

2013 оны 6 сарын 18 \ gants orgiliih bish shvvdee hvnsnii bhv vildvervvd yrd zvgiin taragaar isgedeg yum ter baitygai xotiin oiroltsoo maltai irgedes jinhenе mongol taragnii horongo haigaad oologvi yumdaa manai eej

0 0

**irgen(202.72.245.123)**

2013 оны 6 сарын 18 \ za tiim baijee odoo bid yu idej bolokh talaar l bichee idej bolokh yum khovor tul tsag zav orokhgui baikhaa Malchig yum yumaa une khurged unerkeheed baikhaar iim bolj baigaan khamag malaa ugui khiigeed khot baraadaad end tend zadgai geed irgenshilgui irged ikheer nemegdeed bas болоогui boon khel ам khiiг yum shaardaad teriigeе temtsel gej boodoo ene khodoonii maluudaas bolood mongoliin khogjil zogsokh geed bna shuu odoo khodoonii balainuud maani airagaa uugaad khorsh abgaigaa erguuleed l khagas ukhaantai yabj bgaa

0 0

**зочин(180.149.78.26)**

2013 оны 6 сарын 18 \ Энэ бол монголчууд бидний хувьд эмгэнэл юм .Зах зээл, ардчилалд шилжшээр монголчууд бид нар бух юмаа хийж чадахгүй шахуу болж байна. Муу хэлдэг байсан социализмийн уед бух юмаа оорсдоо хийдэг байсан юм шуу дээ. Ингэж хэлэхэд нэг их хэлсдэхгүй байх. Гэтэл одоо зоосний нүхээр бух юмийг хардагаас болж ийм байдалд хурч байна.Мэргэжлий хяналтийнхан ер юу хийж байна гэхээр хунийг шантаалчилжбайж хунээсхэдэн цаас салгаж байвал тэр ард түмэн хордож байна уу хун ухэж байна тэд нарт хамаагүй. Харин ийм хумууст хууль уйлчидэггүйд иргэн хуний хувьд маш их гайхдаг.

2 0

[Эхлэл](#) [Үнэн](#) [Улс төр](#) [Эдийн засаг](#) [Уул уурхай](#) [Энтертайнмент](#) [Орон нутаг](#) [Спорт](#) [Эрүүл мэнд](#) [Шар](#) [Дэлхий](#)



ХҮН БҮР ТНЭНИЙГ МЭДЭХ ЭРХТЭЙ

[Эхлэл хуудсаа болгоё](#) | [Бидний тухай](#) | [Сурталчилгаа байршуулах](#) | [Вэб сайт хийх](#) | [Холбоо барих](#) | [RSS](#) | [Toolbar татах](#)  
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Мэдээлэл хуулбарлах хориотой.